



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/500

Булган сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалт, Засгийн газрын 2003 оны 196 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд болон бэлтгэх зориулалтын тоног төхөөрөмжийг хадгалах, устгах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн нутаг дэвсгэрт ургаж буй мансууруулах үйлчилгээ бүхий ургамалыг устгах ажилд зориулан 3 208 000 (гурван сая хоёр зуун найман мянган) төгрөг зарцуулсугай.

2.Ургамлыг устгах ажлыг зохих журмын дагуу зохион байгуулахыг Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Л.Ганбаатар) –т даалгасугай.

3.Устгалын зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (дарга Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6393010409